



АРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАРИЛГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэбулган

2017 он

**Аймгийн нутаг дэвсгэрт худалдааны үйл
ажиллагаа явуулах бизнесийн орчин**

Архангай аймаг 55.3 мян.га нутаг дэвсгэртэй, Улаанбаатар хотоос 490 км, Булган, Завхан, Орхон, Өвөрхангай, Баянхонгор аймгаас 190-546 км-ийн зайтай оршдог.

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 93509 хүн ам, 27125 өрх бүртгэгдсэн. Аймгийн төвд нийт өрх хүн амын 22.4 хувь нь оршин суудаг. Мөн 136 ААНБ, 1800 гаруй ажил үйлчилгээ эрхлэгч иргэд эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байна.

Архангай аймаг нь нийслэл Улаанбаатар хот, Өвөрхангай аймагтай засмал замаар хобогдсон.

БНАЛАУ-ын Чампасак муж, БНСУ-ын Чоньян, Чүнчон сум, Ансан, Ганг Нинг хот, АНУ-ын Белинхэм хот, ХБНГУ-ын Кирхайн хот, ӨМӨЗО-ны Хөх хоттай найрамдал хамтын ажиллагаатай ажилладаг. Арилжааны 5 банкны салбартай, худалдааны салбарын 820 гаруй цэг үйл ажиллагаа явуулдаг.

Харилцаа холбоо эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед манай аймгийн нутаг дэвсгэрт үүрэн телефен холбооны 5 оператор үйл ажиллагаа явуулж хэрэглэгчдийн тоо 44.5 мянгад хүрээд байна.

Төвийн эрчим хүчний нэгдсэн системд бүх сум холбогдсон.

Автотехникийн улсын үзлэг тооллогын дүнгээр нийтдээ 9308 авто машинтай, үүнээс 4087 суудлын, 419 автобустой бөгөөд 60 гаруй такси нийтийн тээврийн үйлчилгээнд явдаг.

Улаанбаатар Архангайн чиглэлд өдөр бүр том оврын автобус, сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан тээврийн жижиг оврын автобус үйлчилдэг.

Худалдааны салбарын үүсэл хөгжил


	Бүгд	Хүнсний болон барааны дэглүүр	Хүнсний лангуу	Барааны лангуу	Чингэлэг	Ломбард	Гутал засвар	Эмийн сан	ТҮЦ	Түүхий эдийн ченж	Бар, цайны газар	зочид буудал, зоогийн газар
2001	981	40	224	251	128	4	10	11	187	51	59	16
2002	881	31	159	171	128	5	14	13	230	32	84	14
2003	889	46	193	162	95	3	13	10	245	35	73	14
2004	879	41	277	195	94	1	11	9	102	44	88	17
2005	924	63	350	177	94	4	10	10	67	38	90	21
2006	919	70	349	177	94	4	10	10	62	37	82	24
2007	908	59	350	177	94	4	12	11	46	38	90	27
2008	914	90	352	177	94	4	12	11	20	41	84	29
2009	834	135	310	165	90	4	11	7		27	58	27
2010	828	136	309	165	90	2	10	7		27	57	25
2011	835	144	309	165	90	2	9	7		27	57	25
2012	824	151	302	162	75	6	9	7		28	58	26
2013	826	152	303	162	76	8	9	7		28	59	27

Дээрх тоо баримтаас харахад Архангай аймаг 2001-2013 он хүртэл жижиг мухлаг, чингэлэг, цайны газар, бар, ТҮЦ-ийн тоо жил тутам багасаж барааны болон хүнсний томоохон дэглүүр, зочид буудал зоогийн газрын тоо ихсэж байгаа нь аймгийн худалдааны салбарын хөгжлийг илэрхийлж байна.

Ажиллагсад оны эцэст

	Бүгд	Худалдаа	Нийт дүнд эзлэх хувь
A	1	3	5
1998	37360	1206	3.2
1999	38125	1004	2.6
2000	38639	905	2.3
2001	39215	1493	3.8
2002	39583	1660	4.2
2003	38670	1968	5.1
2004	37859	1829	4.8
2005	38494	1796	4.7
2006	40005	1802	4.5
2007	39795	1857	4.7
2008	39755	1957	4.9
2009	40223	1786	4.4
2010	39362	1752	4.5
2011	39947	1993	5.0
2012	39163	1908	4.9
2013	39831	1991	5.0
2014	40464	2076	5.1

Худалдааны салбарын ажиллагсад



**Ажиллагчдын тооны динамик эгнээний үндсэн
үзүүлэлтүүдийн тооцоолол**

/ өмнөх онтой харьцуулсанаар/

Онууд	Ажиллагсадын тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд %	Хэлхээ цэвэр өсөлтийн бууралтын хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ноогдох утга
1992	1330	-	-	-	-
1993	1406	76	105.71	-5.71	13
1994	1319	-87	93.81	6.19	14
1995	1394	75	105.69	-5.69	13
1996	1318	-76	94.55	5.45	14
1997	1430	112	108.50	-8.50	13
1998	1206	-224	84.34	15.66	14
1999	1004	-202	83.25	16.75	12
2000	905	-99	90.14	9.86	10
2001	1493	588	164.97	-64.97	9
2002	1660	167	111.19	-11.19	15
2003	1968	308	118.55	-18.55	17
2004	1829	-139	92.94	7.06	20
2005	1796	-33	98.20	1.80	18
2006	1802	6	100.33	-0.33	18
2007	1857	55	103.05	-3.05	18
2008	1957	100	105.39	-5.39	19
2009	1786	-171	91.26	8.74	20
2010	1752	-34	98.1	1.9	18
2011	1993	241	113.75	13.75	20
2012	1908	-85	95.73	4.27	19
2013	1991	83	104.35	-4.35	20
2014	2076	85	104.26	-4.26	21

Эндээс үзэхэд 2014 онд худалдааны салбарын ажиллагсадын тооны өсөлтийн нэг хувьд 21 хүн ноогдож байгааг харуулж байна.

Ажиллагчдын тооны динамик эгнээний үндсэн

үзүүлэлтүүдийн тооцоолол

/ суурь онтой харьцуулсанаар/

Онууд	Ажиллагсадын тоо	Суурь абсолют цэвэр өсөлт	Суурь өсөлтийн хурд %	Суурь цэвэр өсөлт бууралтын хурд %
1992	1330	-	-	-
1993	1406	-221	86.42	13.58
1994	1319	-308	81.07	18.93
1995	1394	-233	85.68	14.32
1996	1318	-309	81.01	18.99
1997	1430	-197	87.89	12.11
1998	1206	-421	74.12	25.88
1999	1004	-623	61.71	38.29
2000	905	-722	55.62	44.38
2001	1493	-134	91.76	8.24
2002	1660	33	102.03	-2.03
2003	1968	341	120.96	-20.96
2004	1829	202	112.42	-12.42
2005	1796	169	110.39	-10.39
2006	1802	175	110.76	-10.76
2007	1857	230	114.14	-14.14
2008	1957	330	120.28	-20.28
2009	1786	159	109.77	-9.77
2010	1752	125	107.68	-7.68
2011	1993	366	122.49	-22.49
2012	1908	281	117.27	-17.27
2013	1991	719	156.25	-56.25
2014	2076	746	156.09	-56.09

**Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь
үндсэн үзүүлэлтийн тооцоолол**

ОН	Ажиллагсадыг тоо	t	t ²	Yt	Yt=a+bt
1998	1206	-8	64	-9648	789.3
1999	1004	-7	49	-7028	859.8
2000	905	-6	36	-5430	930.3
2001	1493	-5	25	-7465	1000.8
2002	1660	-4	16	-6640	1071.3
2003	1968	-3	9	-5904	1141.8
2004	1829	-2	4	-3658	1212.3
2005	1796	-1	1	-1796	1282.8
2006	1802	0	0	0	1353.3
2007	1857	1	1	1857	1423.8
2008	1957	2	4	3914	1494.3
2009	1782	3	9	5346	1564.8
2010	1756	4	16	7024	1635.3
2011	1991	5	25	9955	1705.8
2012	1908	6	36	11448	1776.3
2013	1991	7	49	13937	1846.8
2014	2076	8	64	16608	1917.3
	23006		408	22520	
2015		9			1988
2016		10			2058
2017		11			2129
2018		12			2199
2019		13			2270

Дээрхи тооцооллоос харахад худалдааны салбарт ажиллагсадын тоо 2015-2019 он хүртэл 2.6-9.3 хувиар өсөх боломжтой болохыг харуулж байна.

Барилгын салбарын үүсэл хөгжил

Архангай аймгийн барилгын байгууллага анх 1958 онд Ихтамир суманд ХАА-н Барилгын анги нэртэй 210 ажиллагсадтай 14 авто машинтай жилдээ 1.3 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй байгуулагдсан.

Архангай аймгийн төв Цэцэрлэг хотод 1962 онд Барилга угсралтын Контор, 1987 онд барилга угсралтын трест болж өргөжсөн бөгөөд Ихтамир суманд нэгдэл дундын үйлдвэр, Төвшрүүлэх суманд барилгын анги, аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний харъяанд барилга, цахилгаан, сантехник засварын анги, ХАА-н нэгдлүүд тус бүрдээ барилгын бригадтай болж өөрсдийн чиглэл чиглэлээр хүчин чадалдаа тохирсон улсын болон өөрийн хөрөнгөөр барилга угсралт, засварын ажлыг гүйцэтгэдэг болсон байна.

1966 онд ашиглалтанд оруулсан 960 хүүхдийн хүчин чадалтай сургууль барьсан нь аймгийн барилгачдын барьсан анхны 3 давхар барилга байсан юм.

Аймгийн нутаг дэвсгэрт барилгын материалын эрдэс түүхий эд элбэг байдаг нь барилгын материалыг орон нутагтаа үйлдвэрлэх бололцоо бүрдэж байсан юм.

Баригдаж буй барилгын ажлыг хэмждэг гол хэмжүүр бол барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл юм. Энэ нь тухайн барилгыг барих явцад гарсан материал, ажиллагчдын цалин, машин, тоног төхөөрөмжид зарцуулсан нийт зардал юм. Архангай аймагт 2016 оны жилийн эцсийн байдлаар бизнес регистерийн санд бүртгэгдсэн 32 гаруй аж ахуй нэгж барилгын ажил гүйцэтгэж, 780 гаруй хүн барилгын салбарт ажиллаж байна.

Барилгын салбарын үндсэн үзүүлэлт

	Барилга угсралт, их засварын ажил, сая.төг	Барилгын аж ахуй нэгжийн тоо	ажиллагсадын тоо
2000	952.9	8	409
2001	688.3	9	375
2002	1212.2	11	399
2003	743.8	9	392
2004	1357.6	11	313
2005	1063.5	11	268
2006	1013.1	11	423
2007	13330.3	17	444
2008	5134.4	12	549
2009	3620.7	13	580
2010	4691.4	15	572
2011	10058.7	15	670
2012	10064.7	15	660
2013	24552.1	18	719
2014	44338.3	18	782
2015	68187.8	25	775
2016	10196.2	32	780


Аймгийн хэмжээнд өмнөх онуудтай харьцуулахад 2004 оноос барилга угсралтын ажил жигдэрч эхэлсэн байна. 2016 онд нийтдээ 10.2 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийсэн.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг хурдацтай хөгжиж, түүнийг дагаад барилгын салбарын зах зээл огцом өсч, томоохон эрэлтийг бий болгож байна.

Монгол улсын засгийн газраас 100000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж Улаанбаатар хот болон орон нутагт орон сууц барих газрыг олгож, дэд бүтцийг шийдэж өгч байгаа нь барилгын салбарын хөгжилд ихээхэн түлхэц болж байна.

2013 оноос хойш 500-д айлын 18 орон сууц ашиглалтанд орсон байна.

Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын бүтэцийг графикаар харуулав. /2016 он/



Барилга угсралт, их засварын ажил оны үнээр, мян.төг

ОН	Барилга угсралт, их засварын ажил	Үүнээс: Барилга угсралтын ажил
1994	163904.6	137008.6
1995	289811.8	207657.9
1996	491222.3	449505.9
1997	300933.3	282313.9
1998	390901.8	276801.8
1999	762701.5	491884.2
2000	952942.4	894092.4
2001	688296.6	409546.6
2002	1212233.7	854933.7
2003	743803.6	381960.0
2004	1459520.9	934895.8
2005	1640100.0	1096257.8
2006	1013056.8	377970.0
2007	13330272.5	11462552.7
2008	5134396.7	4228596.9
2009	3620665.7	2214107.7
2010	4691417.6	3105179.8
2011	10058692.8	8126800.0
2012	10064771.9	7800281.1
2013	24552096.2	20260424.2
2014	44338272.0	41097148.0
2015	68187818.3	66956498.6
2016	10196211.6	9126270.5

ДУГНЭЛТ

Худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлт аймгийн дотоодын нийт бүтээгдхүүний үйлдвэрлэлтэд 41.0 хувийг эзэлж байгаа нь цар хүрээний хувьд бага биш юм. Тус аймгийн хувьд УБ хоттой 490 км-т засмал замаар холбогдсон, аймгийн 19 сум төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Баруун чиглэлийн хэвтээ тэнхлэгийн зам нь аймгийн төв болон 7 сумын нутгийг дайран өнгөрдөг. Нийт :

- хайрган хучилттай зам 300 гаруй км
- хатуу хучилттай зам 100 гаруй км баригдаад байна.

Мөн эдгээр замын чиглэлийн дагуух томоохон голуудын төмөр бетон гүүрүүдийг барьж дуусгасан. Дээрх мэдээллээс харахад худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдээс гадна албан секторт ажиллагсадын хувьд дийлэнх нь худалдаа эрхлэгчид байдаг. 2014 оны байдлаар 1258 цэг салбар худалдаа, үйлчилгээ эрхэлж байна. Нэг цэг, салбарын цаана 3-4 хүн хамааралтай байдаг гэсэн судалгаа бий. Худалдааг эрхлэх хэлбэрээр нь авч үзвэл: 80.0 гаруй хувь нь жижиглэнгийн, 20.0 хувь нь бөөний худалдаа эзэлж байгаагаас харахад сүүлийн жилүүдэд бөөний цэг, салбарууд бий болсон байна.. Хүнсний бараа татан авалтыг 98.0 хувийг УБ хотоос татдаг. Гутал, хувцас зэрэг барааны 90.0 хувийг Эрээн хотоос татан авалт хийдэг байна. Аймгийн хувьд мал олонтой, малын гаралтай түүхий эдийн үнэ УБ хотын ханштай бараг ижил байдаг зэргээс шалтгаалж хүн амын худалдан авах чадвар сайн байдаг нь худалдаа эрхлэгчдэд таатай байдлыг бий болгож байдаг. Архангай аймгийн хэмжээнд бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр, холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд нь аймгийн нийт нэмэгдэл өртгийн багагүй хувийг эзлэх болсон. Худалдааны салбарын нийт борлуулалт сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд төрөөс жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсний дүнд зээлийн хүү буурч бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад таатай нөхцөл бүрдэж байна.

2005, 2006 онуудад худалдааны салбарын нийт борлуулалт буурч байсан. Энэ нь:

1. иргэдийн амжиргааны түвшин доогуур /нийт өрхийн дийлэнхи хувийг амжирааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхүүд эзэлж байна/ байгаа буюу
2. худалдан авах чадвар нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал
3. үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн хувьд татварын хэмжээ өндөр
4. зээлийн хүү өндөр
5. бусад

шалтгаанууд ихээхэн нөлөөлж байсантай холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд авто тээврийн байгууллагууд хувьчлагдаж хувийн хэвшил авто тээврийн салбарт зонхилох үүрэгтэй болсон байна. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч болон ачаа тээврийн авто машин, таксины үйлчилгээ бүрэн хувьчлагдаж нийт орлого өсч байна. Барилга угсралт их засварын ажлыг бүтцээс харахад сүүлийн жилүүдэд инженерийн барилга байгууламжийн хувь өсөх хандлагатай байна. Орон нутагт шинээр буй зам болон засварын ажил, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шинээр гаргаж буй бэлчээрийн болон гүний худгийн тоо нэмэгдэж байна. Барилгын салбар дахь хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх нь нэг талаар тухайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөгөө талаар тухайн салбар дахь ажлын байрбг нэмэгдүүлэх үндэс нь болох юм. Сүүлийн жилүүдэд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо эрчимтэй өсч 2014 онд хөдөлгөөнт үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 45.0 мянга болж өссөн байна. Албан бус худалдаа эрхлэгчид задгай захад худалдаа хийдэг. Ийм учраас худалдаа эрхлэгчдийн ажиллах нөхцлийг сайжруулахад анхаарч цаашид захын орчинг сайжруулж битүү захтай болгох хэрэгтэй. Худалдаа, үйлчилгээний нэгдсэн тохилог төвүүдийг барьж байгуулахад аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгчид өөрсдөө санаачилга гаргаж аймгийн бодлого чиглэлд санал өгч төлөвлөлтөд оруулах зэргээр худалдаа, үйлчилгээ эрхлэх орчиноо сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Аймгийн 2016 оны жилийн эцсийн мэдээ
2. Аймгийн 2016 оны Статистикийн эмхтгэл
3. Статистикийн шинжилгээ судалгаа хийх гарын авлага
Үндэсний Статистикийн Хороо 2007 он
4. Статистикийн гарын авлага
5. 2014 оны ажил эрхлэлтийн мэдээ
6. www.NSO.mn
7. www.1212.mn



